



**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
САЛБАРЫН УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ДААЛГАВАР**

2023 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 07/01

Улаанбаатар хот

Г Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос
урьдчилан сэргийлэх тухай Г

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын сүүлийн 5 жилийн судалгаанаас үзэхэд нийт 1624 үйлдвэрлэлийн осол, хурц хордлого бүртгэгдсэн 1552 /95.6 хувь/ нь үйлдвэрлэлийн осол, 72 /4.4 хувь/ нь хурц хордлого байна.

2022 онд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 395 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 35.2 хувиар өсч нийт осолдогчдын 38% буюу 149 нь хөнгөн, 48% буюу 189 нь хүнд хэлбэрээр гэмтсэн, 14% буюу 57 нь нас барсан тохиолдол бүртгэгдсэн нь аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж хангалтгүй хэрэгжиж, ажилтан хүний амь нас, эрүүл мэнд хохирох суурь шалтгаан болж байгааг харуулж байна.

Иймээс иргэн, ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгоход ажлын байранд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчинөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тусгайлсан төлөвлөгөө боловсруулж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үр нөлөө бүхий удирдлагын тогтолцоо /менежмент/-г төлөвшүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Үүнтэй уялдуулан уул уурхай, барилга, зам тээвэр, эрчим хүч, боловсруулах үйлдвэр, мал аж ахуй, газар тариалан болон бусад салбарт их бүтээн байгуулалтыг хийж буй нийт ажилтан, ажил олгогч Та бүхэнд хандан “Нэн түрүүнд ажлын байранд аюулгүй ажиллагаа”-г ханган ажиллахыг ДААЛГАЖ байна.

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, үндэсний стандартын хэрэгжилтийг аж ахуйн нэгж, байгууллага түүний нэгж, цех, тасаг, бригадын удирдлага, ажилтан хүртэл бүх шатанд мөрдөж ажиллах;

2. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын бүх түвшинд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хүлээх үүрэг хариуцлагын тогтолцоог тодорхой болгож, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд тусган хэрэгжүүлэх;

3. Ажилтнуудыг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны иж бүрэн сургалт, хөтөлбөрт хамруулан өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх мэдлэг, чадвар, дадлыг ажилтан бүрт эзэмшиүүлэх;

4. Ажлын байран дахь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, З шатны зааварчилгаа өгөх, ялангуяа аюултай ажил гүйцэтгэдэг ажилтанд ажлын

1509230039

байран дахь өдөр тутмын зааварчилгааг ажлын байрны онцлогт нийцсэн бодитой, хариуцлагатай, тогтмол өгч хэвших;

5. Аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн алба, ажилтныг орон тоо, бүтцээр нь ажиллуулж, мэргэшүүлэх, үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг байгуулж, ажиллуулах;

6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг хуульд заасан хэмжээнд төлөвлөн зарцуулж, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ажлын тусгай хувцас, нийтийн болон нэг бүрийн хамгаалах хэрэгслээр ханганд, ажилтнууд зориулалтын дагуу бүрэн хэрэглэж хэвшил байх;

7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээг ажилтан бүрт ойлгомжтой, энгийн, хүртээмжтэй байдлаар төлөвлөж, бодитоор үнэлж, урамшуулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шилдэг арга барил, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх;

8. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны онцлогтоо тохирсон хамгаалалтын төхөөрөмж хэрэгсэл, нэн ялангуяа барилгын гадна орчны хамгаалалтыг олон улсын жишигт нийцсэн зориулалтын материалыаар хийж, барилгын талбайгаас гадагш эд зүйл унах /бусдын эд хөрөнгөнд хохирол учруулах/, техник осолдох зэрэг хариуцлагагүй байдлын улмаас иргэдийг хохицодог явдлыг бүрэн таслан зогсоохтой холбогдсон арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

9. Үйлдвэрлэлийн явцад тавих дотоод хяналтын тогтолцоог нэвтрүүлж, техникийн бүрэн бүтэн байдал, хэвийн үйл ажиллагааг хангах замаар ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

10. Албан даалгаврын биелэлтэд салбарын хөдөлмөр болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчид Засгийн газрын 2023 оны 79 дүгээр тогтоолоор баталсан “Хяналт шалгалтын төлөвлөгөө”-ний дагуу төлөвлөгөөт, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын явцад хяналт тавьж ажиллах.

САЛБАРЫН УЛСЫН
ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ



Б.НАРАНГАРАВ